# ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

facebook.com/Rtcc.m0n
http://rtcc.mrtd.gov.mn
info@rtcc.mrtd.gov.mn
+976 77244409

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

2022 оны 3 дүгээр сарын дугаар

## "Төмөр замын тээврийн салбарын статистик мэдээний нэгдсэн санг бүрдүүлэн ажиллаж байна.



Төмөр замын байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг хэрэгжүүлж төмөр замын салбарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах, ашиглах үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. Хоног, сарын мэдээг төмөр замын байгууллагуудаас цахим хэлбэрээр тогтмол хүлээн авч мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх, боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.




Үндэсний статистикийн хорооны даргын 2009 оны 08 дугаар сарын 11-ний өдрийн 01/92 дугаар тушаалаар батлагдсан улсын тайлан Т-9 маягтын дагуу төмөр замын тээврийн 2022 оны 2 дугаар сар, Төмөр замын статистикийн үндсэн үзүүлэлтийн мэдээ, Захиргааны статистикийн мэдээг нэгтгэн боловсруулж ЗТХЯ болон СҮХ-нд хүргүүлсэн.




2022 оны 2 дугаар сарын статистик мэдээ, мэдээллийг нэгтгэж нийгэм, эдийн засгийн байдалд нөлөөлсөн байдлаар буюу төмөр замын ачаа, зорчигч тээвэрлэлт, ачаа ачилт, зорчигч, ачаа эргэлт, дамжин өнгөрсөн болон тээвэрлэсэн ачаа зэргээр дүн шинжилгээ хийж, олон нийтэд нээлттэй, ил тод мэдээллээ. Ачаа тээврийн статистик мэдээг Чингэлэг тээвэрлэлт, тээвэрлэсэн ачаа, ачаа илгээлт, зогчигч тээвэрлэлтээр сар бүр гарган ЗТХЯ-ны сайдын шуурхай хуралд тогтмол танилцуулан ажиллаж байна.

**“Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим объект, үйл ажиллагаанд гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, нөхөн олгох, санал дүгнэлт гаргах, гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх ажлыг хэрэгжүүлж байна**

Гэрчилгээжүүлэлттэй холбоотойгоор тайлант хугацаанд төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой зарим обьект, үйл ажиллагааг гэрчилгээжүүлэх хүсэлтийг 90 аж ахуй нэгж, байгууллага ирүүлсэн.

| Хүсэлт ирүүлсэн иргэн, хуулийн этгээдийн хүсэлт дараах байдлаар шийдвэрлэгдсэн байна | |
|---|---|
| Баримт бичгийн бүрдэл дутуу шалтгаанаар буцаагдсан | 8 |
| Ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж буцаасан | 3 |
| Ажлын хэсгийн хурлаар дэмжигдсэн | 56 |
| Ажлын хэсгийн хурлаар ороход бэлэн болсон | 4 |
| Хүсэлт ирүүлсэн, одоогоор хянагдаагүй байгаа | 19 |
| Гэрчилгээ олгогдсон | 0 |

Зам тээврийн хөгжлийн сайдын 2022 оны 3 дугээр сарын 09-ны өдрийн А51, А52 дугаар тушаалын дагуу 3 аж ахуйн нэгжийн 3 ширхэг, 2022 оны 3 дугээр сарын 24-ны өдрийн А70 дугаар тушаалын дагуу 4 аж ахуй нэгжийн 4, 71 дүгээр тушаалын дагуу 6 ширхэг гэрчилгээг тус тус хэвлэн Төвийн захирлаар баталгаажуулан авч аж ахуйн нэгжүүдэд хүлээлгэн өгсөн.Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлж хөтлөн, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7.1.8-д заасны дагуу гэрчилгээ олгосон хуулийн этгээдүүдийн мэдээллийг ЗТХЯ-ны ТЗДТБХЗГ-т 2022 оны 3 дугээр сарын 31-ны өдөр тайлагнасан. Гэрчилгээжүүлэлтийн ажлын хэсэгт ажиллах: Ажлын хэсгийн чиг үүргийн дагуу иргэн аж, ахуйн нэгжийн хүсэлтийг “Тусгай зөвшөөрөл, гэрчилгээжүүлэлтийн цахим систем”-ээр хүлээн авч, хэрэгжүүлж ажиллаж байна.



## “Монгол улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүнд шинээр дугаар олгох, баталгаажуулах, мэдээллийн санд бүртгэх, ЗТХЯ-ыг мэдээллээр хангах” ажлын хүрээнд:



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн А/154 дүгээр тушаалын 13 дугаар хавсралтаар батлагдсан “Монгол Улсын хилээр нэвтэрч буй хөдлөх бүрэлдэхүүний бүртгэл хөтлөх, хүлээлцэх журам”-ыг үндэслэн 2022.03.07-ны 83 тоотоор “БТЕГ” ХХК-ийн өөрчлөн тоноглосон 200 болон 624 хагас вагоныг “Монголиан транс ложистик” ХХК-д шилжүүлж, 03.09-ний 86 тоотоор “Эс Би логистик” ХХК-аас хөдлөх бүрэлдэхүүнд эзэмшигч түрээслэгчийн “Т07” кодыг буцаан авч, мөн өдрийн 88 тоотоор “Эйр кэтеринг” ХХК-д эзэмшигч түрээслэгчийн “Т07” кодыг олгон түрээсийн чингэлэг тээврийн 17 тавцант вагоныг, 03.11-ний 92 тоотоор “Төмөр замын зураг төслийн институт” ХХК-д 13 хагас вагонд шинэ дугаар олгож, 03.23-ний 114 тоотоор “Монголын олон улсын чингэлэг тээвэр” ХХК-ийн 398 open top чингэлэг, 03.29-ний 120 тоотоор “Эвт-Аян” ХХК-ийн 417 чингэлэг, 03.30-ний 123 тоотоор “Тавантолгой төмөр зам” ХХК-д 200 тавцант вагоны шинэ дугаар олгож мэдээллийн нэгдсэн санд тус тус бүртгэсэн.

## Хөдлөх бүрэлдэхүүний бүртгэлийн мэдээллийн сангийн модель загварыг ЗТСӨСН платформ дээр үүсгэх, нэр томьёог тодорхойлж оруулах ажлын хүрээнд:



Хөдлөх бүрэлдэхүүний мэдээллийн сангийн бүртгэлийн модель загвар буюу архитектурын элемент програмыг үүсгэсэн. Нэмэлт хөгжүүлэлтийн ажлыг хийж байна. Хөдлөх бүрэлдхүүний бүртгэлийн архитектурын элементтэй холбоотой нэр томьёо үг хэллэгийг төрөлжүүлэн үүсгэж, "Төмөр замын нэр томьёо" фолдерт байршуулсан. Нэмэлтээр шаардлагатай үг хэллэгийг шинээр үүсгэн нэмж баяжуулж байна.

Мөн төмөр замын тээврийн статистик сарын мэдээ №Т-9 маягт, Ачилт буулгалтын хоногийн мэдээний №1 маягт, Төмөр замын ашиглалтын ажлын үндсэн үзүүлэлтийн мэдээ №6 маягт тус бүрийг Монгол Улсын зам тээврийн салбарын нэгдсэн плаформ дээр шинээр үүсгэсэн ба холбогдох үг хэллэг, нэр томьёог шинээр үүсгэсэн..



## "ГТХЗНТ" УТҮГазарын төлөвлөгөөт ажлуудаас



Нэгжүүдийн 02 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтэд, Төвийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд, Нэгжүүдийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд, Захирлын тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж тайланг удирдлагад танилцуулж цахим системд байршуулж мэдээлсэн. Мөн Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Зам, тээврийн хөгжлийн сайдын тушаалын хэрэгжилт, Зам, тээврийн хөгжлийн сайдын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг ЗТХЯ-ны ХШҮДАГ-т цахимаар тайлагнасан.

3 дугаар сарын тухай бүр байршуулах 8 мэдээ, сар бүр байршуулах 3 мэдээ, улирал бүр байршуулах 1 мэдээг бэлтгэн shilendans.gov.mn цахимд байршуулж Сангийн яаманд цахимаар илгээн тайлагнасан ба ЗТХЯ-ны ХШҮДАГ-т цаасаар хүргүүлсэн.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах хуулийн танилцуулга, төвөөс "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн сургалт, Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх, түгээн дэлгэрүүлэх талаар монгол бичгийн сургалтыг тус тус зохион байгуулж нийт албан хаагчид хамрагдсан. Төвийн хэмжээнд хөтлөгдөж буй албан бичиг, тушаал, тогтоол, шийдвэрийг цахим хэлбэрт шилжүүлж, төвийн эйбл програмд байршуулан, удирдлага албан хаагчдыг мэдээллээр хангаж ажилласан.

## Галт тэрэгний хөдөлгөөний 2022 оны зуны, 2022-2023 оны өвлийн цагийн хуваарийн нэгдсэн зурмаг боловсруулж батлах, гүйцэтгэлд хяналт тавих, шинжилгээ хийх.

2021 оны IV улирал, 2021 оны 12-р сар, 2022 оны 02-р сарын тасалдлын тайлан, 2022 оны 1-р сарын зурмагийн тасалдалд дүн шинжилгээ хийж цахим болон цаасан хэлбэрээр ЗТХЯ-нд хүргүүлсэн.
Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан “Цогтцэций-Зүүнбаян чиглэлийн төмөр замаар холбооны утсан хэрэгслээр галт тэрэгний хөдөлгөөнийг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө” болон “МТЗ” ТӨХК-ны галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн зурмагт өөрчлөлт оруулах тухай хүсэлтийг үндэслэн галт тэрэгний хөдөлгөөний 2021-2022 оны өвлийн нэгдсэн зурмагт өөрчлөлт оруулж батлан хуулбарыг 2022 оны 02-р сарын 17-ны өдрийн 50 тоот албан бичгээр холбогдох байгууллагуудад хүргүүлсэн. “Монголын төмөр зам” ТӨХК-ийн боловсруулсан туршилтын тээвэртэй холбоотой техникийн болон технологийн бичиг баримтанд шинжилгээ хийсэн. Шинжилгээний дүгнэлт санал, зөвлөмжийг боловсруулан албан бичгээр “Монголын төмөр зам“ ТӨХК -д хүргүүлсэн.






# Суурь бүтцийн 2022 оны 3-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

2022 оны 03-р сард нийтдээ 50 удаагийн зурмагийн тасалдал бүртгэгдсэнээс:




Суурь бүтцийн 2022 оны 03-р сарын нийт тасалдлыг 2021 оны мөн үетэй харьцуулан үзэхэд 4 нэгж буюу 7.41% -иар буурсан үзүүлэлттэй байна.




## ЗОРЧИГЧИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ЯВУУЛАЛТ (3 дугаар сар)




Зорчигчийн галт тэрэгний явуулалт
3 дугаар сар

| д/д | Өртөөний нэр | Галт тэрэгний тоо | | |
|---|---|---|---|---|
| | | төлөвлөсөн | биелсэн | тасалдсан |
| 1 | Сүхбаатар | 62 | 62 | 0 |
| 2 | Дархан | 82 | 82 | 0 |
| 3 | Шарын гол | 19 | 18 | 1 |
| 4 | Эрдэнэт | 31 | 31 | 0 |
| 5 | Зүүнхараа | 0 | 0 | 0 |
| 6 | Улаанбаатар | 125 | 124 | 1 |
| 7 | Айраг | 2 | 2 | 0 |
| 8 | Бор-Өндөр | 1 | 1 | 0 |
| 9 | Чойр | 24 | 24 | 0 |
| 10 | Сайншанд | 55 | 55 | 0 |
| 11 | Зүүнбаян | 0 | 0 | 0 |
| 12 | Замын-Үүд | 6 | 6 | 0 |
| | **Бүгд** | **407** | **405** | **2** |

# Суурь бүтцийн 2022 оны 3-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

## ЗОРЧИГЧИЙН ГАЛТ ТЭРЭГНИЙ ӨНГӨРҮҮЛЭЛТ (3 дугаар сар)




Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлт
3 дугаар сар

| д/д | Өртөөний нэр | Галт тэрэгний тоо | | |
|---|---|---|---|---|
| | | төлөвлөсөн | биелсэн | тасалдсан |
| 1 | Сүхбаатар – Улаанбаатар | 112 | 107 | **5** |
| 2 | Дархан – Улаанбаатар | 56 | 56 | **0** |
| 3 | Дархан – Шарын гол | 112 | 111 | **1** |
| 4 | Дархан – Эрдэнэт | 56 | 56 | **0** |
| 5 | Зүүнхараа – Улаанбаатар | 0 | 0 | **0** |
| 6 | Айраг – Бор-Өндөр | 16 | 16 | **0** |
| 7 | Улаанбаатар – Чойр | 0 | 0 | **0** |
| 8 | Улаанбаатар – Сайншанд | 56 | 56 | **0** |
| 9 | Сайншанд – Зүүнбаян | 0 | 0 | **0** |
| 10 | Сайншанд – Замын-Үүд | 0 | 0 | **0** |
| **Бүгд** | | **408** | **402** | **6** |

## АЧААНЫ ГАЛТ ТЭРЭГНИЙ ЯВУУЛАЛТ (3 дугаар сар)




Ачааны галт тэрэгний явуулалт
(3 дугаар сар)

| д/д | Өртөөний нэр | Галт тэрэгний тоо | | |
|---|---|---|---|---|
| | | төлөвлөсөн | биелсэн | тасалдсан |
| 1 | Сүхбаатар | 277 | 277 | **0** |
| 2 | Ерөө | 57 | 57 | **0** |
| 3 | Дархан-1 | 37 | 37 | **0** |
| 4 | Дархан-2 | 141 | 140 | **1** |
| 5 | Шарын гол | 49 | 49 | **0** |
| 6 | Салхит | 136 | 136 | **0** |
| 7 | Хөтөл | 27 | 27 | **0** |
| 8 | Эрдэнэт | 66 | 66 | **0** |
| 9 | Зүүнхараа | 428 | 428 | **0** |
| 10 | Толгойт | 210 | 210 | **0** |
| 11 | Улаанбаатар-2 | 318 | 317 | **1** |
| 12 | Улаанбаатар-1 | 57 | 57 | **0** |
| 13 | Амгалан | 59 | 59 | **0** |
| 14 | Багахангай | 30 | 30 | **0** |
| 15 | Мааньт | 46 | 46 | **0** |
| 16 | Багануур | 125 | 125 | **0** |
| 17 | Чойр | 481 | 480 | **1** |
| 18 | Шивээ-Овоо | 80 | 80 | **0** |
| 19 | Олон-Овоо | 29 | 29 | **0** |
| 20 | Айраг | 66 | 66 | **0** |
| 21 | Бор-Өндөр | 24 | 24 | **0** |
| 22 | Өргөн | 10 | 10 | **0** |
| 23 | Зүүнбаян | 9 | 9 | **0** |
| 24 | Улаан-Уул | 5 | 5 | **0** |
| 25 | Сайншанд | 493 | 491 | **2** |
| 26 | Замын-Үүд | 507 | 507 | **0** |
| **Бүгд** | | **3767** | **3762** | **5** |



# Суурь бүтцийн 2020 оны 4-р сарын хөдөлгөөний зурмагын тасалдлын судалгаа тайлан

## АЧААНЫ ГАЛТ ТЭРЭГНИЙ ӨНГӨРҮҮЛЭЛТ (3 дугаар сар)




Ачааны галт тэрэгний өнгөрүүлэлт (3 дугаар сар)

| д/д | Өртөөний нэр | Галт тэрэгний тоо | | |
|---|---|---|---|---|
| | | төлөвлөсөн | биелсэн | тасалдсан |
| 1 | Сүхбаатар – Зүүнхараа | 251 | 247 | **4** |
| 2 | Сүхбаатар – Дархан | 30 | 30 | **0** |
| 3 | Ерөө – Зүүнхараа | 94 | 94 | **0** |
| 4 | Дархан – Шарын гол | 80 | 80 | **0** |
| 5 | Дархан – Салхит | 86 | 86 | **0** |
| 6 | Дархан – Зүүнхараа | 87 | 87 | **0** |
| 7 | Салхит – Эрдэнэт | 141 | 139 | **2** |
| 8 | Зүүнхараа – Улаанбаатар | 432 | 428 | **4** |
| 9 | Улаанбаатар – Багануур | 230 | 227 | **3** |
| 10 | Улаанбаатар – Чойр | 491 | 480 | **11** |
| 11 | Багахангай – Чойр | 20 | 20 | **0** |
| 12 | Багахангай – Улаанбаатар | 42 | 42 | **0** |
| 13 | Багахангай – Багануур | 6 | 6 | **0** |
| 14 | Чойр – Сайншанд | 503 | 492 | **11** |
| 15 | Айраг – Бор-Өндөр | 52 | 52 | **0** |
| 16 | Сайншанд – Зүүнбаян | 37 | 37 | **0** |
| 17 | Сайншанд – Замын-Үүд | 503 | 501 | **2** |
| **Бүгд** | | **3085** | **3038** | **37** |

## Нийт тасалдлыг албадаар нь ангилж үзвэл:




**Татах албанаас (Т) шалтгаалан үүссэн тасалдлыг ангилж үзвэл:**

| № | Тасалдлын шалтгаан | Тохиолдол | Зүтгүүр | Хохирлын хэмжээ | Хоорондын замд саатсан хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хоорондын замд зүтгүүр эвдэрч тусламж дуудсан | 2 | 2ТЭ116УМ - 2 тохиолдол | 493’485₮ | 5 цаг 8 минут |
| 2 | Галт тэрэгний зүтгүүр эвдэрч яваагүй | 4 | 2ТЭ116УМ - 3 тохиолдол<br>2ТЭ25КМ - 1 тохиолдол | 445’314₮ | - |
| 3 | Хоорондын замд илчит тэргэнд гэмтэл гарч үүсэн | 8 | 2ТЭ116УМ - 5 тохиолдол<br>2ТЭ25КМ - 2 тохиолдол<br>2ЗАГАЛ - 1 тохиолдол | 1’127’817₮ | 8 цаг 17 минут |
| 4 | Зүтгүүр эвдэрч хоорондын замд ачаа хаясан | 1 | 2ТЭ116УМ - 1 тохиолдол | 161’723₮ | - |
| 5 | Галт тэрэг зурмагаас хоцорсон | 7 | 2ТЭ116УМ - 5 тохиолдол<br>2ТЭ25КМ - 1 тохиолдол<br>2ЗАГАЛ - 1 тохиолдол | 614’145₮ | 3 цаг 45 минут |
| **НИЙТ** | | **22** | **2ТЭ116УМ - 16 тохиолдол**<br>**2ТЭ25КМ - 4 тохиолдол**<br>**2ЗАГАЛ - 2 тохиолдол** | **2’842’484₮** | **17 цаг 07 мин** |

**Замын албанаас (П) шалтгаалан үүссэн тасалдлыг ангилж үзвэл:**

| № | Тасалдлын шалтгаан | Тохиолдол | Хохирлын хэмжээ | Хоорондын замд саатсан хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Хоорондын замд зам дээр амьтан байсан | 1 | 65’857₮ | 9 минут |
| 2 | Шороон ажил хийж байгаад, шугам гэмтээсэн | 1 | 70’260₮ | 12 минут |
| **НИЙТ** | | **2** | **136’117₮** | **21 минут** |

**Холбооны албанаас (Ш) шалтгаалан үүссэн тасалдлыг ангилж үзвэл:**

| № | Тасалдлын шалтгаан | Тохиолдол | Хохирлын хэмжээ | Хоорондын замд саатсан хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Суман шилжүүлэг хяналтгүй болсон | 8 | 1’390’220₮ | 5 цаг 1 минут |
| **НИЙТ** | | **8** | **1’390’220₮** | **5 цаг 1 минут** |

**СирДП-Е системээс шалтгаалан үүссэн тасалдлыг ангилж үзвэл:**

| № | Тасалдлын шалтгаан | Тохиолдол | Хохирлын хэмжээ | Хоорондын замд саатсан хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Бүхээгний аюулгүй байдлын систем (БАБС) ажиллаж зогссон | 10 | 871’459₮ | 4 цаг 22 минут |
| **НИЙТ** | | **10** | **871’459₮** | **4 цаг 22 минут** |

**Бусад шалтгаанаас үүссэн тасалдлыг ангилж үзвэл:**

| № | Тасалдлын шалтгаан | Тохиолдол | Хохирлын хэмжээ | Хоорондын замд саатсан хугацаа |
|---|---|---|---|---|
| 1 | Зорчигчийн бие муудаж, түргэн дуудаж үзүүлсэн | 2 | 144’626₮ | 26 минут |
| 2 | Зам дээр хүн байсан | 6 | 490’498₮ | 2 цаг 1 минут |
| **НИЙТ** | | **8** | **649’547₮** | **2 цаг 27 минут** |



Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс